

Сайчунгагийн уран бүтээл дэх эмэгтэй дүрийн архетипийн шинжлэл

© Цэдэнжав Цолмон

доктор Ph.D, профессор

Өвөр Монголын Багшийн Их Сургууль

Хятад улс, 010021, Хөх-Хот

tsolmon.ts@163.com

© Лариса Цымжитовна Халхарова

доктор Ph.D., дэд профессор

Доржи Банзаровын нэрэмжит Буриадын Улсын Их Сургууль

Оросын улс, 670000, Улаан-Үд хот, Ранжуровийн гудамж, 24

larihalh@yandex.ru

Хураангуй. *Зорилго.* Энэхүү нийтлэлд Сайчунгагийн бүтээлүүд дэх эмэгтэйлэг архетипийг судална. Сайчунга (Сайнчогу, Сайчунга, эсвэл Сайнчогу гэгддэг) нь чахарын нэрт яруу найрагч, эссе бичигч бөгөөд Хятадын Өвөр Монголын орчин үеийн Монголын уран зохиолын үндэслэгчдийн нэг байв. Одоогийн байдлаар Сайчунгагийн бүтээлийг Өвөр Монголын утга зохиолын судалгаанд эрчимтэй судалж байгаа бөгөөд түүний бүтээл, түүний бүтээлүүдийн үзэл суртал, уран сайхны өвөрмөц байдал, түүний намтар зэрэг олон асуудлыг хамарсан болно. Өмнөх «Сайчунгагийн бүтээлүүд дэх дүрслэлийн систем» нийтлэлдээ түүний бүтээлүүдийг сэтгэлзүйн шинжилгээ, ухамсаргүй байдлын онолын үүднээс шинжилсэн. Энэхүү нийтлэлд Сайчунгагийн бүтээлүүдийг үргэлжлүүлэн судалж, архетипийн онолыг бүтээлч сэтгэл судлалын үүднээс судалж, эмэгтэй дүр төрхтэй холбоотой анима архетипийг тодорхойлсон болно. Анима нь ихэвчлэн эмэгтэй дүрүүдэд биелдэг. Домгийн болон урлагт түүнийг бурхан биетэй, муза, илбэчин эмэгтэйчүүдийн хэлбэрээр, зүүдэнд нь нууцлаг эсвэл чиглүүлэгч эмэгтэй дүрүүдээр дүрсэлж болно. Анима болон түүний аналог болох анимус (эмэгтэйчүүдийн эршүүд зан чанар)-ын тухай ойлголт нь сэтгэл судлал, сэтгэл судлалын шинжлэх ухаанд мэтгэлцээний сэдэв болж, орчин үеийн соёлд ч тусгалаа олсон. Энэхүү судалгаа нь Сайчунгагийн бүтээлүүдээс авсан нотолгоонд тулгуурлан, анима дүрүүдийг шинжлэхийг оролдсон. *Дүгнэлт.* Сайчунгагийн бүтээлүүдээс авсан жишээнүүдийг шинжлэн, гол дүрүүд/баатрууд болон анима/анимус дүрүүдийн хоорондын харилцан үйлчлэлийг дүрслэн харуулснаар энэхүү судалгаа нь анимагийн тухай ойлголтыг судалдаг. Энэхүү өгүүлэлд далд ухамсарыг зөв ойлгож, ойлгоход, эцэст нь амьдралын янз бүрийн үе шатанд эмэгтэйчүүдийн эерэг хөгжилд зайлшгүй шаардлагатай аниматай ажиллах аргуудыг тайлбарласан болно.

Түлхүүр үг: Сайчунга, архетип, дүр, эмэгтэй, Анима, анима дүр, сэтгэл зүйн шинжилгээ, уран сайхны дүр төрх, ухамсаргүй байдал.

Ишлэл

Цэдэнжав Цолмон, Халхарова Л. Ц. Сайчунгагийн уран бүтээл дэх эмэгтэй дүрийн архетипийн шинжлэл // Буриад хэл бол уран зохиол сургуульд (*орос буриад хэл дээр*). 2026. Вып. 2. С. 29–38.

Нэг. Анимацийн учир

Сэтгэл зүйч Карл Густав Юнг (1875–1961) хүний ухамсаргүй, архетип, хамтын ухамсаргүй хэмээн гурван давхаргад хуваан шинжилсэн бөгөөд архетип (Architype)-ийн онолыг дурдсан юм. (архетипийг манайхан хятад хэлнээс “уур хэв” гэх мэтээр орчуулан хэрэглэдэг). Тэрээр архетип нь хувь хүний ухамсаргүй ба хамтын ухамсаргүй хоёр хүчний нөлөөг хүлээдэг гэж үзээд архетипд хүний араншны баг (The persona), сүүдэр (The shadow), анима (Anima), анимус (Animus) болон өөр шинж (The self) багтдаг хэмээн нарийсган судалжээ. Эдгээр архетип нь сэтгэцийн бүхэл бүтэн бүтэц дотроо харилцмал шинжтэйгээр оршидог. Түүний үзхээр эрэгтэй эмэгтэй ялгаагүй хүн бүрийн ухамсаргүй дэх зан чанарт нь нөгөөхийнх нь онцлог оршиж байдаг байна. Тэрээр “дотоод ухамсарын дүр” хэмээн дурдаж, энэхүү дотоод ухамсарын дүр дэх эрэгтэйлэг шинж чанарыг нь анимус, эмэгтэйлэг шинж чанарыг нь анима гэж нэрэлсэн юм. Тухайлбал, “эрэгтэй хүний дотоод ухамсарт орших эмэгтэйлэг шинж чанарыг анима”, “эмэгтэй хүний дотоод ухамсарт орших эрэгтэйлэг шинж чанарыг анимус”^[1] болно. Анима болон анимусын архетип нь эрэгтэй болон эмэгтэйн дотоод ухамсар буюу ухамсаргүй дэх нөгөө этгээдийнх нь шинж чанарын хэсэг болно. Өөрөөр хэлбэл, сэтгэл зүйн хувьд эрэгтэй хүний дотоод ухамсарт эмэгтэйлэг шинж, эмэгтэй хүний дотоод ухамсарт эрэгтэйлэг шинж байдаг гэсэн үг юм.

Хүн хороондын харилцааны явцад эрэгтэй хүний анима, эмэгтэй хүний анимус бүрэлддэг аж. Жишээлбэл эрэгтэй хүний хамаг анх харилцдаг ээж, эгч, охин дүү зэрэг гэр бүлийн хүмүүс анимагийн нь хамгаас хүчтэй буюу тодорхой нөлөөлдөг аж. Тэр тусмаа ээж хүн бол эрэгтэй хүүхдийн хамгийн анх харьцдаг эмэгтэй хүний нэг болно.

Анима болон анимусын архетип хувь хүний удамлал болон хамтын ухамсаргүйгээс ирдэг гэж сэтгэл судлаач К. Юнг үздэг. Тэгэхдээ хувийн ухамсаргүйн өнгөн давхарга нь хувь хүний амьдралын туршлагатай холбоотой байж, хамтын ухамсаргүй бол харин түүний гүн давхаргад хамаарна. Өөрөөр хэлбэл, “тэр нь хүн бүрийн бие дээр адилхан байдаг болохоор бодгаль чанарыг халин гарсан нэгэн сэтгэл зүйн суурь болсон төдийгүй, бид бүгдийн биед түгээмэл оршиж байдаг.”^[2] Тухайлвал, ухамсаргүйн энэхүү анима гэдэг архетип нь эрэгтэй хүний дотоод ухамсарт насан туршид нуугдан оршиж, анимус нь эмэгтэй хүний дотоод ухамсарт оршин байсаар ямар нэгэн онцгой тохиолдол буюу учралын сэдэлтээс болж, далд буюу илээр ямар нэгэн үйл ажиллагаа буюу хэлбэрээр илрэн гардаг аж.

«‘Анима’-гийн архетипийн гол агуулга нь эрэгтэй хүн эмэгтэйтэй харилцах явцад хуримтуулсан бодит туршлага, эрэгтэйн ухамсаргүй дэх биеэрээ туулсан мөртөө мартагдсан буюу дарагдсан эмэгтэйн тухай туршлага, эрэгтэйн сэтгэцийн удамлалаар олсон эмэгтэйн тухай төрмөл хандлага болно»^[3] Араншны баг гэдэг бол хүний гадаад ертөнцөд харуулдаг дүр буюу нийгмийн шаардлагад зохицуулахын төлөө бүтээсэн дүр болно. Харин жинхэнэ зан чанар нь биш юм. Тиймээс эрэгтэй эмэгтэйн аль нь ч гэсэн нийгмийн, соёлын, иш ёсны дагуу уур дүрээрээ байх биш, араншны баг зүүх хэрэгтэй болно. Энэ үед анима буюу анимус дарам-

¹ 荣格著 冯川编:《荣格文集: 让我们重返精神家园》, 改革出版社, 1997年, 86页

² 荣格著 冯川、苏克译:《心理学与文学》, 生活·读书·新知三联书店, 1987年, 第53页

³ 向青:《荣格-阿尼玛和阿尼姆斯原型理论基于性别批评视角的研究》, 中国知网

тад учирна. Сүүдэр гэдэг нь хүний оюун санааны ертөнц дэх амьтны архетип, өөр би-д хүлээн зөвшөөрөгдөөгүй бөгөөд дарагдаж байгаа хэсгийг хэлдэг. Зохиолч хүний туурвилын сэтгэл зүй уран дүрийн бүтээлтэд «анима» буюу «анимус» нь илэрлээ олдог.

К. Юнгийн үзхээр «архетип-ийн» илрэх хэлбэр нь «бэлгэдэл» болно. Тэрээр «бэлгэдэл гэдэг нь нэр томъёо, нэрийдэл, тэрчлэн өдөр тутамын амьдрал дундах үзэгдэл болно. Гэвч уламжлалт тодорхой утгаас гадна, онцгой агуулагдахуунтай, тэр нь бидэнд авч хэлбэл бүрэг бараг, үл мэдэгдэх буюу халхлагдсан зүйл болно»^[1] гэж дурдсан юм. анима болон анимус бэлгэдлээр өөрийгөө илрүүлнэ. Ани-ма болон анимус нь дүрийн архетипийн хувьд дүр болон зохиогчийн туурвилын сэтгэл зүй лүгээ гүн холбоотой байдаг.

Хоёр. Сайчунгагийн анимагийн архетип

Сайчунгагийн (1914–1973) уран бүтээлийг «анима» «араншны баг» «сүүдэр-ийн» архетипийн хараагаас судлах бүрэн боломжтой байгаа юм. Энд түүний «анима-гий» голцуу жишээлэн шинжлэхийг зорьж байна. Өмнө дурдсан мэтээр эрэгтэй хүний дотоод ухамсарт оршидог эмэгтэйд шинж чанарыг дэргэдэх эмэгтэйчүүд, жишээлбэл ээж, эгч, охин дүү нь нөлөөлөх боломж их байдаг.

Сайчунгагийн анимад холбогдох хүн нь охин дүү болон ээж нь юм. Тэр тус-маа охин дүү нь түүний туурвилын сэтгэл зүйн гүн дэх анимагийн архетип бол-но. Охин дүү Удваллүмбэ (1916–1965) нь айлын ганц охин, аав ээж болон таван ах дүүгийнхээ хайран дунд эрх данхи өсчээ. «Бүдүүн хар нүдтэй, ханхилхан бага биетэй хүн байсан»^[2] гэдэг. Анх Гүл хөхийн хуучин тэргүүн сумны Довдон гэдэг хүнд мордож, нэг охинтой болоод сүүлд нь салжээ. Тэгээд Загастайн Хүйсийн сүмийн лам эмч Дамбиням гэдэг хүнтэй суужээ. Удваллүмбэ уран үйлд сайн, Дамбиням зураг зурахдаа сайн хүн байсан гэдэг. Сайчунгагийн ач хүү Бадамжа-выг сурвалжилхад «жаахан шиг биетэй хүн байсан. Сүүлийн суусан өвгөн нь лам хүн, бурхны хөрөг зурж урладаг. Тэгээд нутаг усныхан нь хуар Удвал, хуажан Ням гэж хочилдог байсан юм гэнэ билээ»^[3] хэмээн дурсаж, сүүлийн нөхөртэйгээ жаахан эсгий гэрийн үүдэнд тавиур цаг тависан жижигхэн ширээний хоёр талд суугаад авхуулсан зураг явуулж өгөөд «миний авга мөөм (эмээ) морь унаандаа сайн, ажилд сайн хүн байсан. Дөч тавин газраас цагаан сарын шинийн нэгэнд давхиж ирээд ээждээ золгодог. Ер нь бушуу шалмаг, ажилч хүн. Намайг арван хэдэн настай байхад ноос савж эсгий хийдэг. Авга мөөм (эмээ) цагаан эсгий дээр чинь хар ноосоор хуар тавиад, өлзий утас гарган өнцгийг нь чимэж сайхан хий-дэг байлаа» гэж хуучилсан юм. Нутаг усныхан нь уран үйлдээ сайн «Убүү мөөм (эмээ)» буюу «хүйсийн мөөм (эмээ)» хэмээн хүндлэн дууддаг гэнэ.

Сайчунга Тэмдэглэлдээ «бид ах дүү зургуулын дотор хамгийн илүү хайртай садан ануу даруй охин дүү мөн болой. Юуны тул хэмээвээс, таван хөвгүүний дунд ганц охин төрсний тул буюу. Тэр дээр хөвгүүн болбоос эцэг эхийн хөрөнгө буян ба гэр хотолдоо дураар тохуурхах боловч, охин хүн болбоос харийн газар очиж хадам эхийн дор халтайгаар амьдарах тул өр өвдөлтэй бишүү. Иймийн тул

¹ 申荷永:《心理分析:理解与体验》,三联书店,2004年

² 2024 оны 7-р сарын 4-нд Ч. Монголжавын хамт гэрт нь хүрч анх сурвалжилсан ба 2025 оны 6-р сарын 28-нд утсаар сурвалжилав.

³ 2024 оны 7-р сарын 4-нд Ч. Монголжавын хамт гэрт нь хүрч анх сурвалжилсан ба 2025 оны 6-р сарын 28-нд утсаар сурвалжилав.

миний бие охин дүүгээ санах бүр нүд минь бүрхэлзэн, элэг минь шимшрэх бүлгээ. Ер миний зан болбоос бүстэй хүнээс бүсгүй хүнийг янагладаг ануу мөнхүү миний охин дүүгийн хайраас гарч ирсэн болой. Би болбоос бүстэй нөхдийг үзэх цаг тур цээжнээ баяр ба зориг ануу төрөх боловч бүсгүй эгч дүү нарыг үзэх цаг тур хайр ба хөөрхийлөл инуу миний сэтгэлийг эзэлдэг бүлгээ. Энэ ч бас миний охин дүүгийн хайраас гарч ирэх сэтгэл буюу»^[1] гэснээс олон сүвэгч гарч ирнэ. Юуны урьд Нүүдэл соёлтой монголчууд гэр бүл зуураа охин хүүхдийг гадуурхан үзэх үзэгдэл байдаггүй байв. Яриангүй ургийн ёсны дагуу харьд мордоно. Тиймээс зохиогч «охин хүн болбоос харийн газар очиж хадам эхийн дор халтай амьдарах тул өр өвдөлтэй» гэж охин хүүхдийн хувь заяаг өрөвдөж байдаг сэтгэлээ илтгэв. Залгаад «ер миний зан болбоос бүстэй хүнээс бүсгүй хүнийг янагладаг ануу мөнхүү миний охин дүүгийн хайраас гарч ирсэн болой» гэсэн нь эмэгтэй хүнийг өрөвддөг сэтгэл зүйн буй болсон шалтгаанаа дурдсан буюу өөрийн «анима-гийн» архетипээ шижимлэсэн учир болно. «Бүсгүй эгч дүү нарыг үзэх цаг тур хайр ба хөөрхийлөл инуу миний сэтгэлийг эзэлдэг» нь түүний сэтгэл зүй дэх эмэгтэйн зан чанарын нэг онцлог болно.

Зурагаас нь харахад Удваллүмбэ том нүдтэй, зурайсан хөмсөгтэй, түнтгэрдүү хацартай, өтгөн хар үстэй хүн байв.

Дүү нь ч ахдаа онцгой хайртай байжээ. Бадамжав гуайн «их зохиолч авагыг Японоос ирээд байхад өглөө үнээгээ саачихаад зуу гаруй газрын холоос морьтой давхиж ирээд уулзаж байсан юм» гэсэн нь Сайчунгагийн тэмдэглэл дэх «...охин дүүгийн мордсон гэр инуу айхавтар хол дээр охин дүү ч бас өөртөө төрхөмлөн харьж ирээд над лугаа учирмой хэмээх чимээ соносдсон тул охин дүүгээ ирэхүйг хүлээлзгэн байбай», «сонсхуул охин дүү минь энэ өглөө үүр гэгээрэхээс урьд бо-соод хамаг юмаа төхөөрч, нар гарахаас урьд мордож, нэг удаа ч амрашгүйгээр довтлон хүрч ирвэй хэмээмүй» гэж тэмдэглэсэн уулзалтыг хэлж байгаа юм. «Ах охин дүү бологч бид хоёр ануу бие биеээ үзмэгцээ царай ануу хэдийбээр баярлах байдал илрүүлж байвач, бид хоёрын нүд инуу аль хэдийн чийгдэх байдалтай болжухуй». Уулзсандаа баярлаж байвч, Цаана нь уярал, гуниглал, бодол алгасал нь будлиантай илэрч сэтгэлийг нь индлүүлэн байгаа ажээ. Тэгээд ах дүү хоёул «халуун цээжний баяр ба энэлэлээ ханатал хэлэлцэн суувай».

«Дүү минь уяруун, зөөлөн эгшгээрээ ийн дуулруун: Аав юугаа өвөр дээр ах дүү зургуул хөө\ Албандаа мордахуй тур ах минь ганцаар бишүү\Ээж эчээн төрөхүй тур эгч дүү зургуул хөө\Энэ л албанд явсан ах минь, ганцаар хөө ... хэмээн дуулсаар нүднээс эчээн бөмбөрүүлхэд би ч бас тэссэнгүй уйлжухуй» гэж тэмдэглэснээс ахаа санасан охин дүүгийн уян зөөлөн сэтгэл нь дуу, нулимс болон гадагшилж, мөн охин дүүгээ дандаа санадаг ах хүний дүүгээ мөрөөддөг зүрхний гүн дэх хайр нь нулимс болон асгарчээ. Энэ бүхэн далд ухамсрын гүнд дарагдсаар ирсэн бие бие рүүгээ тэмүүлдэг мөрөөдөл болно. Тэгээд «охин дүү инуу миний өвөр дээр толгойгоо тавин байхад, миний бие дүүгийнхээ гарыг барьж уйлан суувай. Яамбар элэгсэлтэй аж. Энэрэлт аав ээжийн халуун хайрын дунд төрөн хүмүүжсэн ах дүү хэмээгч, яс махны тасархай, ах дүү хэмээгч инуу юутай ээнэгшилтэй аж. Нэгэнт дотор цээжний элэгшээл инуу ноцон гарах энэ цаг миний бүх бие инуу шимширсээр мэдрэлгүй болчухуй». «Би-гийн» багаасаа санан хайрла-

¹ Сайнцогт Н. Сайнцогтын Н. бүрэн зохиол 5 // ӨМ-ын ардын хэвлэлийн хороо. 1999 он. 172-р тал.

сан охин дүүгийн уян зан араншин, хувь заяа, дүр төрх оюун санааных нь гүнд хоногшин үлдэж, өөрийнх нь эрэгтэйн шинж чанар дахь мөрөөдөнгүй, уян сэтгэл, ээнэгшил, ноцон гарах «элэгшээл» бүхий «анима», даруй эмэгтэйлэг шинж чанар болжээ.энэхүү тэмдэглэл дэх «бигийн» сэтгэл зүйн хандлага нь К. Юнгийн хэлдэг «эрэгтэй хүний дотоод ухамсарт орших эмэгтэйлэг шинж чанар» бүхий уян зөөлөн, билиг чанарыг харуулж байгаа юм.

Гурав. Сайчунгагийн анима ба түүний бүтээл дэх уран дүр

Зохиогч буюу хүүрнэгч нь эрэгтэй байх тохиолдолд түүний дотоод ухамсарт орших эмэгтэйлэг шинж чанар буюу анимагийн нөлөө нь эмэгтэй дүрд уусан илэрч байдаг. Даруй уран зохиолд эрэгтэй хүний нүдээр эмэгтэй дүрийг хүүрнэгч нь үнэндээ эмэгтэйгээр дамжуулж, эмэгтэй хүнд чиглэсэн хайр сэтгэлээ илэрхийлж байгаа хэрэг төдий бус, эрэгтэйн дотоод ухамсарт орших эмэгтэйлэг шинж чанараа илэрхийлж байгаа талтай. Сайчунгагийн эхний үе буюу Японд суралцаж байсан үеийн сэтгэл зүй нь маш будлиантай, эргэлзээтэй, дотоод сэтгэлийн зөрчилтэй байдаг. Эрдэм сурч үндэстэнээ сэхээрүүлэх хүсэл зорилгодоо хөтлөгдөх алсын хүслэн, нутагтаа хоргодох тээнэгэлзэл, нутгаа санах, элгэн саднаа дурсах мөрөөдөл хайр, хөгжлийг бахархах орчин үеийн ухамсар, нутгийн хоцрогдмол байдалд эмзэглэх бодол санаашрал, эмэгтэйчүүдийн гоо сайхныг дээдлэн бахдах хайр догдлол, тэдний нийгмийн хүлээслд баригдсан хувь заяаны шудрага бусд санааширсан бодол алгасал, эрх чөлөөний эрэл тэмүүлэл ... гэх мэт ээнэгшил ба тэмүүлэл, өрөвдөл ба зоригжуулал, ганцаардал ба мөрөөдөл, гуниглал ба эрмэлзлэл, тээнэгэлзэл ба хайгуул бүхий дотоод сэтгэлийн ертөнц дэх зөрчилт сэтгэлгээ уран бүтээл болон гүн ухаалаг өгүүлэлд нь илэрч байдаг. Түүний бүтээлийг туурвилын сэтгэл зүйн үүднээс үзэхэд эмэгтэй хүний гоо сайхан буюу «сайхан хүний» имежийн цаана хамтын ухамсаргүй агуулагдаж бий.

Эмэгтэй зохиолч, шүүмжлэгч Вүүлф (1882–1941) бол мөн эмэгтэйн шүүмжлэлийн чухал төлөөлөгч юм. Тэрээр «бидний сэтгэлд эрэгтэй эмэгтэй хоёр зүйлийн эзэн мэдэгч хүчин бий, нэг нь эрэгтэй, нөгөө нь эмэгтэй. Эрэгтэй хүний бодолд эрэгтэй хүн нь эмэгтэйгээс давуу, эмэгтэй хүний бодолд эмэгтэй хүн нь эрэгтэй хүнээс давуу. Жам ёсны бөгөөд таатай орших хэлбэр нь харин энэ хоёрын хамтын эсэг амьдрал юм. Оюун санааны талаар хамтралцах үед, хэрвээ эрэгтэй хүн байх тохиолдолд түүний тархин дахь эмэгтэйн элемент нь үйлдэл үзүүлж, хэрвээ эмэгтэй хүн бол тархин дахь эрэгтэйн элементтэйгээ заавал харилцана»^[1]. Түүний энэхүү «хос чанарт бие цогцын» үзэлт буюу хүйс ялгалын талаарах танилтыг шүүмжилж, хос хүйс ялгалын эсэнгүй оршихыг дээдэлдэг үзэлт нь даруй хүн чанарын бүтэн сайхныг эрхэмлэх үзэл санаа болно. Энэ нь К. Юнгийн «анима» «анимусын» архетипээр хүний бүрэн бүтэн зан чанарыг хөөцөлддөгтэй адил юм.

Сайчунгагийн бүтээлд охин дүүгийнх нь нөлөөлсөн анимагийн архетипийн мөр сүүдэр бүхий эмэгтэйн дүрийн хүүрнэл цөөнгүй бий. «Сэтгэлийн ханьдахь» «Аргал түүх охин» «Цэцэглэх нулимс», «Манай монголын мандах дуундахь» захидлын «Арван дөрөв» буюу «Булгийн усан тур унах цэцгийн дуун»^[2], «Элс манхны эх нутагдахь» «Найман сарын арван тавнаа», Монгол улсад байхдаа бич-

¹ 凯特米力特著(钟良明译):《性的政治》, 社会科学出版社 1999年, 第37页

² «Хөх туг» сонин. 34-р хугацаа. 1941 оны 11-р сарын 8-ны өдөр.

сэн «Саальчин хоёр дүү минь» гэх мэт олон бүтээлүүдэд бүтээгдсэн дүр буюу имежээс анхаарч болно.

«Аргал түүх охиндахь» залуу охин бол зохиогчийн хүсэл, сэтгэлийн дүр болно. Тэмдэглэл зохиол ба намтар зохиол дахь үнэн хүнээс эхтэй анима нь зохиолчийн туурвилын сэтгэл зүйд гүн нөлөөлдөг. Харь нутгаас «элс манхны эх нутгаа санах тутам хамгийн урьдаар хайрт охин дүү чамайгаа санадаг» түүний сэтгэлийн ертөнцөд охин дүүгийнх нь дүр байн байн тодорч, «бүсгүй хүнийг янагладаг» сэтгэлийг нь индлүүлэгч хайрын сурвалж буюу дүрийн анима болдог байсан байна. «Аргал түүх охинны» эхний бадаг нь: Ажил тур дуртай бөгөөд зовол зүдгүүрээс үл айх, \ Ааш зөөлөн бөгөөд насан залуу хөөрхөн охин\ Ар нуруун дээрээ араг юугаан үүрсээр\ Аялуулан дуулж саруул тал тур гарч ирвэй.

Энэхүү охны араг үүрсэн үйл хөдлөлөөс нүүдэл соёлын ухамсаргүй дэх дүрийн бэлгэ тэмдэг харагдаж, «аялгуулан дуулж» яваагаас нь дотоод сэтгэлийн баясангүй цовоолог төрх мэдрэгдэнэ. «Улиархаг сайхан хоёр хар нүд» нь өмнө дурдсан зураг дахь охин дүүгийн нүдийг эрхгүй санагдуулах бөгөөд «урлуун сайхан арван хуруу» нь «хуар Удвалын» уран гарын уян уран хөдлөлийн суугдал дүрээс ирэлтэй ч байж болох юм. Ахтайгаа уулзсан охин дүү нь дуу дуулж байсан ба ахынхаа «өвөр дээр толгойгоо тавин» ээнэгшиж байсан тэрхүү хоногшил дүр нь эелсэг уян ааль, хүний сэтгэлийг уяраах, муу муухай хүсэл тачаалыг унтраах, үнэн хайрын гал бадраах «үзэсгэлэнт хөнгөлүүн бие юүгээн найгалзуулсаар» аргал түүж яваа хөдөлмөрч баясангүй, гоо сайхан бүсгүйн дүрийг бүтээх анима болжээ. Төгсгөлд нь «эрдэнэ мэт эрдэм хайж, үндэс угсааныхаа гал голомтыг бадраахаар эрэл хайгуулд яваа залуусыг бэлгэдсэн юм»^[1].

Хөөдөөгийн бүсгүйчүүдийг өр өвдөж «хэрвээ энэ мэтээр монгол бүсгүйчүүд инуу мөн хуучин хэвээрээ хар хадуугаар ажиллан амьдрахуй тур хүрвээс, монгол орноо төрсөн аливаа бүсгүй хүн инуу хүний төрлийн баяр цэнгэлийг олохуйя бэрхтэйг үл өгүүлэн, манай монголын хүн ам ануу улам улам хасагдан цөөрөх дээр, ард олны махбод ч улам доройтон муужрах аймаг угсаатны мөхөж сөнөхүй тур хүрэх болой»^[2] хэмээн гүнзгий ухаарч бүсгүйчүүд бол «эр нөхрийн тачаангуйн хүслийг хангахын ануу огт бус» гэж бодгаль биеийн чөлөөлөлтөд урилан ухааруулсан байдаг.

«Саальчин хоёр дүү минь» яруу найрагт бүгд найрамдах монгол ард улсад суралцаж байхдаа тэндхийн эрх чөлөөтэй амьдралдаа «Ухмал модон суулгаа барьж цомцойн суугаад\ Ундралт сүүг асгаруулан саах залуу дүү»-г хараад, өөрийнх нь «анима» буюу нутагтаа байгаа охин дүүгийнх нь дүр эрхгүй сэтгэлд нь тодрон гарч ирсэн байдаг.

Өглөөний салхинд хийсэн ээдрэх өтгөн үс нь ч\Өнгөт цэцэгт тунаран тогтох тунгалаг нүд нь ч\ Өнгө гэрэлтсэн бор улаан бондгор хацар нь ч\ Өр хайрт миний дүүтэй ямар адилхан бэ.

Энд дүрслэгдсэн «өтгөн үс, тунгалаг нүд, бор улаан бондгор хацар» зэрэг зүс царайн тод онцлогоос энэхүү уран дүрийн архетип нь Удваллүмбэ мөн гэдэг нь андашгүй мэдрэгдэж байна. Харин цааш нь нөгөө л «охин хүн болбоос харийн

¹ Цолмон.Ц. “Сайчунгагийн уран бүтээл дэх дүрийн шинжлэл”. Баруун хойдын үндэстний их сургуулийн эрдэм шинжилгээний бичиг. 2022 оны 1-р хугацаа

² Төвчууд Байгал. “Сайчунгагийн зохиол бүтээл”. ӨМ-ын шинжлэх ухаан технэг мэргэжилийн хэвлэлийн хороо. 2014 он. 496-р тал

газар очиж хадам эхийн дор халтай амьдарах тул өр өвдөлтэй бишүү» гэдэг зохиогчийн зөөлөн сэтгэл (эрэгтэй хүний дотоод ухамсарт орших эмэгтэйд шинж чанар) нь эмзэглэж, үнэн дүр, урлагийн төсөөлөмжөөр дараах бадаг зохиогджээ.

Харах нүдээ хар алчуураар даран боолгож\Хамаг биеээ омогт эрчүүдээр хумхин тэврүүлж\ Халуун нулимсаа асгаж харьд богтлуулсан\Хайрт дүүгийн минь зүрх гаслангаар цохилдог

Энэ бол тухайн нийгмийн хамтлагийн соёлын орчноос түүний сэтгэлд үлдээсэн «сүүдэр»-ийн архетип, бүсгүйчүүдийн хувь заяанд хандсан зовнил санаашралынх нь үндэс болно. «... Нүцгэн хөл нь саарьтан хагарсан\ Нөхөөсөн дэлтэй үнээ саан сууж байсан» дүр бол бүхий л монгол бүсгүйчүүдийн тухайн үеийн бодит дүрслэл юм. Дарангуй засаглалын нийгэмд эмэгтэйчүүд «зөвхөн ноёрхогч ба дагалтын харьцаанаас ноёрхох уу, дагалдах уу гэдгийг сонгоно. Энэ бол тэдний хувь заяа»^[1]. Эмэгтэйн эрхийн үзэлтэд үүнд үндэслэн, «эмэгтэйн уян эелсэг, хөнгөмсөг даруу, дэмжигч, сэтгэлийг ойлгогч, өршөөнгүй, аялдагч, зөнч, сэргэг, өгөөмөр зан араншин нь эрэгтэйн зоримог, эрдүү, эрэлхэг, бие даасан, шийдэмгий, эрс, хадам, оюунч болон сэтгэлээ хязгаарлагч араншнаас хол дээгүүр байдгаас эмэгтэйчүүд өөрийнхөө чансааг баримтлан, шинэ нэг зүйлийн эмэгтэйчүүдийг халамжлах эш ёсны сургаалаар хуучин уламжлалт эрэгтэйн эш ёсны сургаалыг орлуулах хэрэгтэй»^[2] хэмээн уриалдаг. Хөөрхийлөлтэй хувь заяагаа өөрчлөхөд «ноёд ихэс», «хутагт данжаад», «зандран зодогч хадам эх балмад эр»-ийн дарлалыг нэвт танин, «Хүний дарлалыг жигшин заногч зоригт дүү минь\ Хөмхийгөө зууж хилэнгээ бадруулан...» ноцоохыг хүсэн уянгалсан нь бачлагдаж, хүлээслэгдэж, дарлагдсан бүхий л эмэгтэйчүүдийг бодгаль биеийн чөлөөлөлтөд уриалсан хэрэг юм.

«Хөх торгон тэрлэг» гэх сүүлийн үеийн уран бүтээлийнх нь төлөөлөл болсон бэсрэг найраглал дахь «Улаан бондгор хацартай\ Удын навчин хөмсөгтэй\ Улиархаг зантай хүүхний\ Уран ч гэдэг нь яриангүй» хэмээн дүрсэлсэн «хүрэн бор царайтай» «Уран нарийн гарынх нь\ Хөдөлж байх нь түргэн гэж\ Улбар шар эмжээрийг\ Даруулж байх нь сайхан гэж» гэсэн хүүхний дүрийн дүрслэлийн цаана нөгөө уран охин дүүгийнх нь дүр төрх буюу Сайчунгагийн анима нөлөөлж бий.

Дөрөв. Зүүд, төсөөлөмжийн дуурвил ба түүний бэлгэдлийн утга

Туурвилын сэтгэл зүйн хараагаас зохиогчийн зүүд, архетип ба ухамсаргүй, бэлгэдэл зэрэг мотивуудыг холбон үзэхэд шинэ утга учир гарч ирэх нь мэдээж билээ. Зүүдний туурвил ба уран төсөөлөмж нь орчин үеийн Сайчунгагийн уран бүтээлийн урлагийн шинэчлэлийн чухал арга барлын нэгээр хэрэглэгдэж, урлагийн орон зай, имаж, бэлгэдлийн урлагийн гоо сайхны цогцлолд чухал үйлдэл үзүүлсэн юм.

З.Фрейд (1856–1939)-ийн үзэхээр хүний хүсэл шунал нь далд ухамсарт дарагдснаас зүүд илэрдэг гэж үздэг бөгөөд зохиол туурвил бол «сэрүүн зүүд» хэмээн тайлбарладаг. «Хий бодлын хөдөлгөх хүч бол ханаагүй дур хүсэл, удаа болгоных нь бодол нь дур хүслийн илрүүлэл, хүний хүсэл бодлыг нь ханаагаагүй бодит ахуй лугаа холбоотой байдаг»^[3]. Тиймээс зүүд нь хүний дотоод сэтгэлийн хүсэл

¹ 王晓华:《身体美学导论》, 中国社会科学出版社 2016年, 128页

² 郭晓梅、陈晴钰:《荣格分析心理学的女性主义解读》, 南京大学学报, 2013年第2期

³ [奥]西格蒙德·佛洛伊德著, 侯国良译:《作家与白日梦》, 文艺理论研究, 1981年, 第3期

нь биелэгдэж чадахгүй үе дэх дотоод сэтгэлийн бэгтрэлтэй холбоотой мөртөө урлагийн туурвилын сэтгэл зүйд ч холбогддог.

Сайчунгагийн «Элс манхны эх нутаг»-дахь «Найман сарын шинийн долооноо» бол далд ухамсраас хөөрсөн амь насны догдлолыг бичсэн гойд сайхан сэтгэл зүйн өгүүллэг юм. «Би» үдэш унтах гэртээ ороход тооноор туссан сарны гэрэл, ширээн дээрх тосон лавын гэрлийг дарсан байна. «Гэрийн хаяагаар тойрон хэвтсэн үхрийн хивэх дуун сонсдхоос бус, өчүүхэн ч чимээ анир огтгүй» үдшийн сэлүүн орчинд «...гэнэт эдгээр нам тогтуун байдлыг эвдэх хөлийн чимээ ойртон сонсдсоор нэгэн хүн орж ирэв. Тийн үзвээс тормогор хар нүдээ инээмсэглэн, улиархаг царайгаа гэрэлтүүлсээр танхилуун ааш гарган орж ирээд, шууд миний өвөр дээр гараа тавин түшин суужухуй. Түүний лондон хар нүдний цэцгийг ширтвээс цэцэг дээр тогтсон шөнийн шүүдрийн усны үрэл ануу гэгээхэн сарны туяагаар мөлтгөнөн үзэгдэж ахуу мэт байнам. Түүний хүрэн улаан хацрыг шинжэлвээс шар ногоон навч цэцгийн дунд улалзан харагдах болсон жимс мэт байнам» гэж зохиол эхэлдэг. Нүд, царай, зан ааль, хүрэн улаан хацар зэрэг нь мөн өмнө задалсан дүртэй галбирын хувьд адилавартай байгаа юм. «Тэр зөөлөн дулаан гараар миний гарыг барихуйя, түүний халуун цээжний янаглал ануу миний зүрхнээ нал нал гэж баймуй» гээд цааш нь хөгжих тэр эмэгтэйн сэтгэлийн өчил, аажмаар хөгсөх сэтгэл догдлол, «би»-гийн махбодын талаарах сэрэл, далд ухамсраас долгилох хөгсөл зэрэг бол өөрийгөө чөлөөлсөн эмэгтэйн «дотоод ухамсарын дүр» юм. Зохиогч хэн нэгнийг тодорхой дурдаагүй «нэгэн хүн» гэсэн ба «энэ инуу нэгэн зүүдэн болов уу, эсхүүл нэгэн үнэн хэрэг болов уу. Зүүдэн ч байтугай, үнэн хэрэг ч байтугай. Унших олон авгай нар, ганц залуу хүний янаг сэтгэлийн гайхамшгийг амтлан үзэх ажаамуу» хэмээн төгсгөснөөс бид үүнийг зүүдний туурвил хэмээн ойлгож болно.

Юу ч гэсэн энэ бүтээл нь уулзаагүй удсан хоёр залуугийн эчнээ ухамсар дахь «дарагдсан хүсэл хайр»-ын лэврүүлэл, зохиогчийн ухамсаргүйн давхаргаас илрүүлсэн хоёр дүрийн тус бүрийн анима ба анимус болно. Бодгаль биеийн чөлөөлөлтийн нэг чухал агуулга бол хайрын чөлөөлөлт, өөр би-ийн чөлөөлөлт болно. XX зууны эхэн үеийн монгол оронд ч үнэндээ тухайн үеийн бүсгүйчүүд үнэнхүү хайр сэтгэл, хүсэл бодлоо ингэж шуурхай илэрхийлж чадах нь ч цөөн байсан нь мэдээж билээ. Тиймээс Сайчунга энэхүү бүсгүйн дүрд хайр хүслээ зоримог, хөдлөнгүй, нааланхай, өөрийн бодлоо илэн далангүй өчхийг дагалдан, биеийн хөдлөл галбирын хөдлөлөөр далд ухамсарын гүн дэх хүсэл догдлол аажмаар ирмүүсч буйг дүрслэж анимаусыг нь олгож бичсэн нь тухайн үеийн зохиол туурвилд оруулсан зоригтой эрэл хайгуул гэж болно.

«Цэцэглэх нулимс» бол гайхалтай гойд имежээр «дотоод ухамсарын дүр» бүтээсэн имемизмийн шүлэг, эчнээ ухамсар дахь зүүдний ертөнц буюу хий бодлын шидээр бүтээсэн уран сайхны ертөнц болно. Саруул саран, асар үзэсгэлэн хүмүүд цэцэг, ааль уярангүй сэргэлэн сайхан охин, алиархан инээмсэглэх нүдний цэцгий, арайхан нээгдэгч цэцгийн цоморлог, цэцгийн цоморлогт туссан нулимсан үрэл гэх мэт имежээр хэлхэн бүтээсэн бэлгэдэлт санаа ахуйг хий сэрэл, зүүд зэрэглээнээр цогцолсон ухамсаргүйн туурвил хэмээн үнэлж болох юм. Байгалийн гойд үзэмж лүгээ хослон зохицсон охны ганц дусал нулимснаар хайрын уужим сансар цогцлов. «Аялгуулан дуулсаар ойртон хүрч ирээд/ Арван хурууны уран нарийн үзүүрээр/ Анхилан үнэртэх цэцгийн навчийг барьж» буй дүрийн цог заль гайхалтай бөгөөд «Асгаран дусах нулимсний үрэл инуу гялтганан/ Агаарт мярал-

зах одны гэрэл лүгээ адил/ Арайхан нээгдэгч цоморлогийн дотор унахуйя/ Анхааран байсан залуу миний зүрх инуу/ Алсхийн биширч дундашгүй» болсны дотор, хоёр дүр (цэцэгт нулимсаа дусаасан охин ба цэцгийг нандигнан суулгагч «би») эчнээ ухамсрын догдлол, дарагдсан хайрын хөгсөл тэмүүлэл нь нулимсан үрэл болон нулимсан дусал шингэсэн хүмүүд цэцгийг сэтгэлийн «цэцэрлэг»-тээ суулгасан бэлгэдлийн имежид нуугдаж бий. Имежийн архетипийг норшин тайлбарлахгүй ч гэсэн мэргэн уншигчид маань андахгүй биз дээ.

«Булгийн усан тур унах цэцгийн дуун» бол далд ухамсрыг бичсэн сэтгэл зүйн уянгын өгүүллэг. Зохилын баатар сайхан охин бол К.Юнгийн хэлдэг «дотоод ухамсарын дүр» болно. Тэр охны тунгалаг нүд, «бөнваын хар бөгөөд булагийн мэт зөөлөн үс», улаан хацар, нарийхан сайхан хуруу, дуу дуулж буй зэрэг галбир төрх нь «Аргал түүх охин»-ы дүртэй их төстэй байгаа нь цаашид Сайчунгагийн анимагийн архетипийг ч мэдрүүлнэ. Тэр охны барьсан удвал цэцэг бол түүний ариун хайрын бэлгэдэл имеж болно. «Аливаа амины дээдийг олсон бидний амь ч баярын үндсэн, хайрын булаг» болохоор махбодын шуналд минчүүрсэн хорт архи тур согтуурсан доорд явдалтан, «бүсгүй хүнийг доорд төрөлтөн хэмээн үзэгч» балмад эрчүүдэд өгөхгүй» гэх шийдэлт буюу цэцгээ хэнд өгөх нь сонголт бол бодгаль би-гийн чөлөөлөлтийн тунхаг болно. Энэхүү дүрийн гадаад галбир төрхийн дүр дүрслэл нь өмнө задалсан анимагийн онцлог бүхий дүртэй адилаватар талтай нь ажиглагдана.

К. Юнгийн архетипийн онол, 3. Фрейдийн ухамсаргүй сургаал зэрэгт үндэслэн, Сайчунгагийн орчин үеийн уран бүтээлийн анима, анимус, эчнээ ухамсар ба түүний туурвилын сэтгэл зүйн хандлагыг чадан ядан шинжэллээ. Текстын судлал, хээрийн шинжлэлд үндэслэн Сайчунгагийн уран бүтээлийн эмэгтэй дүрийн архетипийг анх илрүүлж, түүний уран дүр дэх илрэлийг задлан, зохиогчийн туурвил дахь зүүд, уран төсөөлөмжийн дүр, имежийн сэтгэл зүйн хандлага чиглэл, онцлогийг хайн сүвэгчилж хийсэн маань Сайчунгагийн судлалд нэмэрлэсэн нэгэн шинэ хараа юм.

Статья поступила в редакцию 28.05.2026; одобрена после рецензирования 01.06.2026; принята к публикации 09.06.2026.

The Female Archetype in the Works of Saichungga

Tsedenzhav Tsolmon

Ph.D, Prof.

Inner Mongolia Normal University

China, 010021, Hoh-Hot

tsolmon.ts@163.com

Larisa Ts. Khalkharova

Dr. Sci. (Philology), A/Prof.

Dorzhi Banzarov Buryat State University

Russia, Ulan-Ude

larihalh@yandex.ru

Abstract. The article examines the female archetype in the works of Saichungga. Saichungga (also known as Sainchogtu) was a prominent Chahar poet, essayist, and one of the founders

of modern Mongolian literature in the Inner Mongolia Autonomous Region of the People's Republic of China. Today, Saichungga's literary heritage is actively studied in Mongolian literary studies in Inner Mongolia, with research addressing a wide range of topics, including analyses of his works, their ideological and artistic characteristics, and the author's biography. In our previous publication, *The System of Imagery in the Works of Saichungga*, his writings were analyzed from the perspectives of psychoanalysis and the theory of the unconscious. The present article continues the investigation of Saichungga's literary heritage by examining archetypal theory from the perspective of the psychology of creativity and identifying manifestations of the Anima archetype associated with female imagery. The Anima is predominantly embodied in female characters. In mythology and art, it may appear as a goddess, muse, or sorceress, while in dreams it manifests itself as a mysterious woman or guide. The concept of the Anima and its counterpart, the Animus (the masculine aspect within a woman), remains a subject of debate in psychology and psychoanalysis and continues to be reflected in contemporary culture. Based on textual material drawn from Saichungga's works, this study undertakes an analysis of Anima imagery. Conclusions. Through the analysis of examples from Saichungga's works and the description of interactions between the main characters and Anima/Animus figures, this study elucidates the essence of the Anima concept. The article also explains approaches to engaging with the Anima that are important for the interpretation and understanding of the subconscious and, ultimately, for a deeper understanding of women's psychological development at various stages of life.

Keywords: Saichungga, archetype, persona, woman, Anima, anima-character, psychological analysis, artistic image, the unconscious.

For citation

Tsedenzhav Tsolmon, Khalkharova L. Ts. The Female Archetype in the Works of Saichungga. Buryat Language and Literature in School. 2026; 2: 29–38 (In Mong).

The article was submitted 28.05.2026; approved after reviewing 01.06.2026; accepted for publication 09.06.2026.